

## ТӨСӨЛ

Засгийн газрын 2021 оны ... дугаар сарын ...-ны  
өдрийн .... дугаар тогтоолын хавсралт

### ТӨРӨЛ БҮРИЙН ҮҮЛДЭР, ОМГИЙН МАЛЫГ ҮРЖҮҮЛЭХ БҮС, БАЙРШЛЫГ ТОГТООХ ЖУРАМ

#### *Нэг. Нийтлэг үндэслэл*

1.1. Монгол Улсад хянан баталгаажсан уугуул үүлдэр, омог болон гадаад улсаас оруулж ирсэн, үржлийн зориулалтаар нутаг шилжүүлсэн үүлдэр, омог, тэдгээрийг ашиглан бий болгосон үржлийн малыг тогтоосон бүс нутагт үржүүлэх, сайжруулагчаар ашиглах, генетикийн нөөцийг бүрэн ашиглах, хадгалж хамгаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад журмын зорилго оршино.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын харъяат иргэн, хуулийн этгээд болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын иргэн, гадны хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн мал сүрэгт адил хамаарна.

1.3. Үүлдэр, омгийн малыг үржлийн зориулалтаар бойжуулах, зөвшөөрөгдсөн бүсэд худалдан борлуулах үйл ажиллагааг эрх бүхий этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

#### *Хоёр. Хэрэгжилтийг зохион байгуулах*

2.1. Монгол Улсад хянан баталгаажсан үүлдэр, омгийн малыг батлагдсан үржил селекцийн ажлын хөтөлбөрийн хүрээнд ашиг шимийн чиглэл, онцлогт тохируулан цөм болон үржлийн сүргийг бий болгох замаар дасан зохицсон, ашиг шимээ бүрэн өгөх боломжтой уугуул орчинд үржүүлж хамгаална.

2.2. Гадаад улсаас оруулж ирсэн болон үржлийн зориулалтаар нутаг шилжүүлсэн үүлдэр, омгийн малыг нутагшуулах, зөвшөөрсөн бүсэд үржил селекцийн ажлыг явуулах, удам зүйн үнэлгээ хийх, нутагшилтын байдлыг тодорхойлох замаар цэврээр нь сонгон үржүүлж хамгаална.

2.3. Малын үүлдэрлэг байдал алдагдах, тоо толгой цөөрөх, устаж мөхөх эрсдлээс хамгаалах зорилгоор үүлдэр, омгийн малаас үржүүлгийн бүтээгдэхүүний дээж, сорьц, цуглуулгыг бий болгох, тусгай орчинд хадгалж, хамгаалах, үр хөврөл үйлдвэрлэх, үржүүлэгт ашиглах асуудлыг эрх бүхий төрийн үйлчилгээний байгууллага гүйцэтгэнэ.

2.4. Малд гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх, үр хөврөл шилжүүлэн суулгах асуудлыг мэргэжлийн байгууллагын хяналтын дор эрх бүхий этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

2.5. Үржлийн мал өсгөн бойжуулах, худалдан борлуулах эрх бүхий иргэн, хуулийн этгээд нь тухайн бүсэд зөвшөөрөгдсөн үүлдэр, омгийн малыг худалдан борлуулах бөгөөд цөм сүргийн шаардлагыг бүрэн хангасан, ялган тэмдэглэж бүртгэлжүүлсэн, удам гарваль баталгаажсан байна.

### *Гурав. Хяналт тавих*

3.1. Аймаг, нийслэлийн Мал үржлийн алба, Сум, дүүргийн хөдөө аж ахуйн тасаг энэхүү журмын хэрэгжилтэнд технологийн хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллана.

3.2. Журмын хэрэгжилтийг хангуулах, гарсан зөрчлийг хянан шийдвэрлэхтэй холбогдон гарах асуудлыг бүх шатны мал үржлийн хяналтын улсын байцаагч хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

.....о О о.....

“Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам”-ын 1 дүгээр хавсралт

А.МОНГОЛ УЛСАД ХЯНАН БАТАЛГААЖСАН УУГУУЛ ҮҮЛДЭР, ОМГИЙН МАЛЫГ ҮРЖҮҮЛЭХ БҮС БАЙРШИЛ

№	Малын төрөл	Үүлдэр, омгийн нэр	Ашиг шимийн чиглэл	Цөм сүргийн байршил	Үржүүлэх зохистой бүс нутаг	Тайлбар
1	Адуу	Монгол үүлдэр	Уналга-эдэлгээ, мах, сүү, хурд	Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Ханх сумаас бусад	Бүх нутгаар	
2		Галшар үүлдэр	Уналга -эдэлгээ, хурд	Хэнтий аймгийн Галшар, Баянхутаг сумд	Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгууд болон Хээрийн бүс	
3		Тэс үүлдэр	Хурд-уналга-эдэлгээ	Увс аймгийн Тэс, Зүүнговь, Баруунтуруун Завхан аймгийн Тэс, Баянхайрхан, Баянтэс сумд	Увс, Завхан, Ховд аймаг болон Эх нууруудын хотгор	
4		Дархад омог	Уналга-эдэлгээ-мах	Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Ханх сумд	Тагийн болон тайгын бүслүүр	
5		Мянгад омог	Уналга-эдэлгээ-хурд	Ховд аймгийн Мянгад, Дарви сумд	Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нууруудын хотгор, Говийн бүс	
6		Өндөршил омог	Хурд-уналга-эдэлгээ	Дундговь аймгийн Өндөршил сум	Дундговь, Дорноговь, Өмнөговь аймгууд болон Говь, хээрийн бүс	
7	Тэмээ	Монгол үүлдэр	Ноос-мах-сүү, уналга эдэлгээ	Бүх нутгаар	Бүх нутгаар	
8		Төхөм Тунгалагийн хүрэн үүлдэр	Ноос-мах	Говь-Алтай аймгийн Төгрөг, Шарга, Халиун сумд	Дорноговь, Дундговь, Төв, Өвөрхангай, Өмнөговь аймгаас бусад тэмээ үржүүлэх боломжтой бүх нутагт	

9		Ханын Хэцийн хүрэн үүлдэр	Ноос-мах	Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Булган сумд	Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Дорноговь аймгууд болон Говь цөлийн бүс	
10		Галбын говийн улаан үүлдэр	Мах-ноос	Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо сумд	Өмнөговь, Өвөрхангай, Баянхонгор, Дорноговь аймгууд болон Говь цөлийн бүс	
11		Ламын гэгээний улаан үржлийн хэсэг	Сүү-ноос	Баянхонгор аймгийн Баянлиг, Богд, Баянговь, Жинст сумд	Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай аймгууд болон Говь цөлийн бүс	
12		Олдохын хүрэн бор омог	Мах-ноос	Дундговь аймгийн Хулд сум	Дундговь аймаг	
13		Монгол үүлдэр	Мах	Бүх нутгаар	Бүх нутгаар	
14	Үхэр	Сарлаг	Сүү-махны	Архангай аймгийн Тариат, Өвөрхангай аймгийн Уянга, Ховд аймгийн Мөст, Завхан аймгийн Их-Уул, Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Хөвсгөл аймгийн Их-Уул сумд	Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Завхан Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий аймгууд болон Өндөр уул, хангайн бүс	
15		Дорнод Монголын улаан үүлдэр	Мах	Дорнод аймгийн Халхгол, Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумд	Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгууд болон Хээрийн бүс	
16	Хонь	Монгол хонь	Мах-өөхний бүдүүн ноост	Төв аймгийн Баянцагаан, Дундговь аймгийн Эрдэнэдалай сумд	Бүх нутгаар	
17		Барга үүлдэр	Мах-өөхний бүдүүн ноост	Дорнод аймгийн Хөлөнбуйр сум	Дорнод, Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймгууд болон Хээрийн бүс	

18		Үзэмчин үүлдэр	Мах-өөхний бүдүүн ноост	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Сэргэлэн сумд	Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь аймгууд, говь, хээрийн бүс	
19		Керей үүлдэр	Мах-өөхний ууцан сүүлт	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сум	Баян-Өлгий, Ховд аймгийн Өндөр уулын бүсийн сумд	
20		Байдраг үүлдэр	Мах-өөхний бүдүүвтэр ноост	Баянхонгор аймгийн Жаргалант сум	Сайжруулагчаар ашиглах боломжгүй	Тоо толгой цөөрсөн
21		Баяд үүлдэр	Мах-ноосны бүдүүвтэр ноост	Увс аймгийн Малчин, Зүүнговь, Хяргас сумд	Увс, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Архангай,Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Төв аймгууд болон Эх нууруудын хотгор, Говь хээрийн бүс	
22		Говь-Алтай үүлдэр	Мах-өөхний бүдүүвтэр ноост	Говь-Алтай аймгийн Бугат, Цээл, Тонхил сумд	Говь-Алтай, Баянхонгор аймгууд болон Их нууруудын хотгор Говийн алтай, Говийн бүс	
23		Дархад үүлдэр	Мах-өөхний бүдүүвтэр ноост	Хөвсгөл аймгийн Цагааннуур, Улаан-Уул, Ренчинлхүмбэ сумд	Хөвсгөл, Архангай, Булган аймгууд болон Өндөр уул, таг, тайгын бүслүүр	
24		Сартуул үүлдэр	Мах-өөхний бүдүүвтэр ноост	Завхан аймгийн Эрдэнэхайрхан, Алдархаан сумд	Завхан, Архангай, Орхон аймгууд болон Өндөр уул, Эх нуурын хотгор ба Говийн алтайн бүс	
25		Торгууд үүлдрийн хэсэг	Мах-өөхний ууцан сүүлт	Ховд аймгийн Булган	Ховд аймаг болон Говийн бүс	
26		Тамир үүлдрийн хэсэг	Мах-өөхний бүдүүвтэр ноост	Архангай аймгийн Ихтамир сум	Архангай аймаг болон Хангай, ойт хээрийн бүс	

27		Хотонт үржлийн хэсэг	Мах-ноосны	Архангай аймгийн Хотонт сум	Архангай, Булган, Өвөрхангай аймгууд болон Ойт хээрийн бүс	
28		Буриад омог	Мах-ноосны	Дорнод аймгийн Дашбалбар сум	Дорнод аймаг болон Хээрийн бүс	
29		Баянгол омог	Мах-ноосны	Өвөрхангай аймгийн Баянгол сум	Өвөрхангай аймаг, Хээрийн болон говийн бүс	
30		Сутай үүлдэр	Мах-өөх-бүдүүвтэр ноосны	Ховд аймгийн Дарви сум	Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нуурын хотгор, Говийн бүс	
31		Цагаан-Уул үүлдэр	Мах-өөх-бүдүүвтэр ноосны	Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сум	Хөвсгөл, Завхан, Архангай аймгууд болон Ойт хээрийн бүс	
32		Бүрэгхангай үржлийн хэсэг	Мах-ноосны	Булган аймгийн Бүрэгхангай сум	Булган, Архангай аймгууд болон Ойт хээрийн бүс	
33		Сайнцагаан омог	Мах-өөх-ноосны	Дундговь аймгийн Сайнцагаан сум	Дундговь, Өмнөговь, Дорноговь аймгууд болон Говийн бүс	
34		Баянбулаг омог	Мах-бүдүүвтэр ноосны	Баянхонгор аймгийн Баянбулаг сум	Баянхонгор, Завхан, Говь-Алтай аймгууд	
35		Ямаа	Монгол үүлдэр	Ноолуур	Бүх нутгаар	Бүх нутгаар
36	Алтайн улаан үүлдэр		Ноолуур	Ховд аймгийн Алтай, Үенч, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Бугат сум	Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нуурын хотгор ба Говийн бүс	
37	Залаа жинст Эдрэн үүлдэр		Ноолуур	Баянхонгор аймгийн Шинэ жинст, Баян-Өндөр сумд	Баянхонгор, Говь-Алтай аймгууд болон Говь, цөлийн бүс	
38	Завхан буурал үүлдэр		Ноолуур	Завхан аймгийн Дөрвөлжин сум	Завхан аймаг болон Говийн бүс	
39	Эрчмийн хар үүлдэр		Ноолуур	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сум	Хөвсгөл, Булган, Архангай, Завхан, Өвөрхангай аймгууд болон Хангайн бүс	

40		Өлгийн улаан үүлдэр	Ноолуур	Увс аймгийн Өлгий, Наранбулаг сумд	Увс, Ховд, Говь-Алтай аймгууд болон Их нууруудын хотгор, Говийн бүс	
41		Баяндэлгэрийн улаан үүлдэр	Ноолуур	Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сум	Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь, Төв аймгууд болон Говийн бүс	
42		Бөмбөгөрийн улаан омог	Ноолуур	Баянхонгор аймгийн Бөмбөгөр сум	Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймгууд болон Говь,хээрийн бүс	
43		Галшарын улаан омог	Ноолуур	Хэнтий аймгийн Галшар сум	Хэнтий, Дорноговь, Говьсүмбэр аймгууд болон Говь, хээрийн бүс	
44		Дэлгэрэхийн улаан омог	Ноолуур	Дорноговь аймгийн Дэлгэрэх сум	Дорноговь, Дундговь аймгууд болон Говийн бүс	

.....о О о.....

“Төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс, байршлыг тогтоох журам”-ын 2 дугаар хавсралт

Б.ГАДААД УЛСААС ОРУУЛЖ ИРСЭН БОЛОН ҮРЖЛИЙН ЗОРИУЛАЛТААР НУТАГ ШИЛЖҮҮЛСЭН ҮҮЛДЭР, ОМОГ, ТЭДГЭЭРИЙГ АШИГЛАН БИЙ БОЛГОСОН ҮРЖЛИЙН МАЛЫГ ҮРЖҮҮЛЭХ БҮС БАЙРШИЛ

№	Малын төрөл	Үүлдэр омгийн нэр	Ашиг шимийн чиглэл	Цөм сүргийн байршил	Үржүүлэх зохистой бүс нутаг	Ашигласан үүлдэр омог
1	Адуу	Араб, Англи ба бусад	Хурдны чиглэл	-	Төвийн болон газар тариалангийн бүс	
2		Казак, Якут, Буриад, Башкир ба бусад	Махны	-	Төвийн болон газар тариалангийн бүс	
3		Гоёлын болон бусад		-	Хязгаарлахгүй	
4	Үхэр	Сэлэнгэ үүлдэр	Махны	Булган аймгийн Сэлэнгэ, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумд	Булган, Архангай, Сэлэнгэ, Өвөрхангай аймгууд болон Ойт хээрийн бүс	Казакийн цагаан толгойт
5		Буган халиун үүлдрийн хэсэг	Сүү-махны	Төв аймгийн Батсүмбэр сум	Төв, Булган, Орхон, Сэлэнгэ аймгууд болон газар тариалангийн бүс	Алатау, Швицийн бор
6		Геррефорд, Лимузин, Ангус, Казахын цагаан толгойт, Халимаг ба бусад	Махны	Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Хүдэр сумд	Газар тариалангийн бүс нутаг	
7		Симменталь Монтебиллъярд болон бусад	Сүү-мах, мах-сүүний хосолмол	-	Төв, Булган, Орхон, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгууд болон газар тариалангийн бүс	
8		Хангай үүлдэр	Ноосны	Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Булган аймгийн Бүрэгхангай сум	Сэлэнгэ, Төв аймаг болон Ойт хээр, газар тариалангийн бүс	Алтай, Ставрополь



9	Хонь	Орхон үүлдэр	Ноосны	Сэлэнгэ аймгийн Орхон сум	Сэлэнгэ, Дархан, Орхон, Булган аймгууд болон Ойт хээр, газар тариалангийн бүс	Цыгай, Прекос
10		Сүмбэр үүлдэр	Арьсны	Говьсүмбэр аймгийн Сүмбэр сум	-	Оросын каракуль
11		Тал нутгийн цагаан үүлдэр	Ноос-махны	Хэнтий аймгийн Хэрлэн сум	Хээрийн болон газар тариалангийн бүс	Цыгай
12		Ерөө үүлдрийн хэсэг	Мах-ноосны	Сэлэнгэ аймгийн Ерөө сум	Сэлэнгэ аймаг болон газар тариалангийн бүс	Кубышев, Ромнимарш, Хойт Кавказ
13		Алтанбулаг үржлийн хэсэг	Мах-өөхний ууцан сүүлт	Төв аймгийн Алтанбулаг сум	Төв, Дундговь, Өвөрхангай аймгууд болон Ойт хээр, хээрийн бүс	Гиссар, Эдельбай
14		Жаргалант үржлийн хэсэг	Мах-ноосны	Төв аймгийн Жаргалант сум	-	Грузины нарийвтар ноост
15		Суффолк, Дорпер, Гиссар, Эдельбай ба бусад	Махны	Төв, Сэлэнгэ, Хэнтий аймгууд болон газар тариалангийн бүс	Тухайн бүс нутагт сайжруулагчаар, хэрэгцээний эрлийжүүлэгт ашиглах	-
16		Меринос, Романов, Прекос, Карачаев, Тушинск болон бусад	Мах-ноос, ноос-мах, сүү	Төв, Сэлэнгэ, Хэнтий, Булган, Дархан-Уул аймгууд болон тариалангийн бүс	Тухайн бүс нутаг сайжруулагчаар, хэрэгцээний эрлийжүүлэгт ашиглах	-
17		Уулын бор үүлдэр	Ноолуур	Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Баяннуур, Булган сумд	Баян-Өлгий аймаг болон Өндөр уулын бүс	Уулын Алтай
18	Говь гурван сайхан үүлдэр	Ноолуур	Өмнөговь аймгийн Булган сум	Өмнөговь аймаг болон Говь, цөлийн бүс	Дон орчмын үүлдэр	

19		Өнжүүл үржлийн хэсэг	Ноосны	Төв аймгийн Өнжүүл сум	-	Зөвлөлтийн ноосны үүлдэр
20		Тоггенбург, Заанен, Альпин	Сүүний	-	Төвийн бүс	-

.....о О о.....